

Тойм ба үндэслэл

<p>Үзүүлэлт</p>	<p>4. Албан болон албан бус боловсролын аль аль нь СББӨ-ийн өвлүүлэн уламжлуулалтыг бэхжүүлж, СББӨ-ийг хүндэтгэхийг дэмждэг эсэх.</p>	
<p>Үнэлгээний хүчин зүйлүүд</p>	<p>Энэ үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайлагнасан үндэсний түвшний дөрвөн хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>4.1 Дадлагажигч болон өвлөн уламжлагч нар СББӨ-ийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад оролцох ба/эсвэл өв соёлоо идэвхтэй танилцуулах.</p>	<p>OD 107(e)</p>
	<p>4.2 Олон нийт, бүлгүүд, хувь хүмүүст хүлээн зөвшөөрөгдсөн СББӨ-ийг дамжуулах арга, арга барилыг сурч эсвэл бэхжүүлж, албан болон албан бус боловсролын хөтөлбөрт хамруулах.</p>	<p>Зүйл: 14(a)(i); Article 14(a)(ii) OD 180(a)(iii)</p>
	<p>4.3 Олон нийт, бүлгүүд, ТББ-ууд эсвэл өвийн институциудаас хэрэгжүүлж буй СББӨ болон түний дамжуулалтыг бэхжүүлэхтэй холбоотой боловсролын хөтөлбөрүүд болон/эсвэл гадуурх үйл ажиллагаануудыг дэмжих.</p>	<p>OD 109</p>
<p>4.4 Багш бэлтгэх хөтөлбөр, албан бус боловсролыг сургагч багш нарт зориулсан хөтөлбөрүүд нь СББӨ-ийг боловсролд нэвтрүүлэх, түүнийг хамгаалах арга барилыг агуулдаг.</p>	<p>Зүйл: 14</p>	
<p>ТХЗ болон бусад үзүүлэлтийн холбоо хамаарал</p>	<p>Тогтвортой хөгжлийн зорилгууд: Энэхүү үзүүлэлт нь ТХЗ 4.7 “Соёлын олон талт байдал, соёлын тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлэх боловсрол”-д болон мөн ТХЗ 11.4 “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хамгаалах хүчин чармайлтыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.” гэсэн заалттай нийцэж байгаа юм.</p> <p>Бусад үзүүлэлтийн холбоо хамаарал: Үзүүлэлт 4,5 ба 6 нь СББӨ-ийн дамжуулалт болон боловсролд хамаатай боловч тус бүр тодорхой хэсгийг онцгойлон тодотгодог. Үзүүлэлт 4 нь албан ба албан бус боловсролыг аль алиныг нь авч үзэж, СББӨ-ийн тархалтыг бэхжүүлэх мөн түүнийг хүндэтгэхийг дэмжихэд чиглэдэг. Үзүүлэлт 5 нь бага, дунд боловсрол, СББӨ нь сургалтыг хэрхэн бэхжүүлэх талаар голчлон анхаарч байгаа бол үзүүлэлт 6 нь дээд боловсролыг, ялангуяа ийм боловсрол нь дадлага, дамжуулалтыг бэхжүүлэх, нийгэм дэх СББӨ-ийн байр суурийг судлахад чиглэгдсэн тохиолдолд хамаарна. Эдгээр гурван үзүүлэлтийг Үзүүлэлт 2 болон 3 -аас ялгах зүйтэй учир нь үзүүлэлт 2,3 нь СББӨ-ийн талаар суралцах бус харин түүнийг хамгаалах, удирдахад оролцож буй хүмүүсийг сургахад чиглэгддэг. Үзүүлэлт 12 нь боловсролын хөтөлбөр, үйл ажиллагааг онцлох бодлогод хамаатай юм.</p>	

<p>Үйл ажиллагааны үндэслэл</p>	<p>Энэхүү конвенцид боловсролыг улс орны үндэсний хэмжээнд хамгаалах үүрэг хариуцлагад онцгой байр суурь эзэлдэг хэмээн үздэг. 14(а)(i) зүйлд олон нийт, ялангуяа залуучуудад чиглэсэн боловсролын хөтөлбөрүүдийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн бол харин 14(а)(ii) зүйл нь холбогдох орон нутаг, бүлгүүдийн боловсролын хөтөлбөрүүдэд хамаарна. Мэдлэг дамжуулах албан бус хэрэгслийн хамаарлыг 14(а)(iv) зүйлд онцлон тэмдэглэсэн. Улс орнууд эдгээр үүргээ биелүүлэхийн тулд боловсролын өргөн хүрээний бүтээлч стратеги, арга барилыг боловсруулсан. Олон үйл ажиллагаа нь хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулагдан ердийн хичээлийн өдрөөс гадуур явагддаг. Эдгээрийг ихэвчлэн улсын боловсролын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон дэмждэг ч олон нийт, бүлгүүд, төрийн бус байгууллагууд болон бусад байгууллагуудаар хангадаг бөгөөд албан ёсны сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг биш байж болно. Энэхүү арга барил нь боловсролын тогтолцоог илүү өргөн хүрээнд бэхжүүлэх шинэлэг сурган хүмүүжүүлэх аргуудыг санал болгох боломжтой, ялангуяа дадлагажигч болон өвлөн уламжлагч нар сурган хүмүүжүүлэх өөрийн арга барилыг ашиглан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцох.</p>
<p>Түлхүүр үг</p>	<ul style="list-style-type: none"> ● Албан боловсрол ● Албан бус боловсрол ● Дадлагажигч болон эзэмшигч ● Багтаасан/Оролцуулан ● Хамт олон, бүлэг, хувь хүн ● Гадуурх үйл ажиллагаа ● ТББ ● Өвийн байгууллагууд ● Сургалт

Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар

<p>Хяналтын ач тус</p>	<p>Энэ үзүүлэлт нь тухайн улсын нутаг дэвсгэр дэх шинэлэг боловсролын хөтөлбөр, стратегийг тодорхойлж, хянахад тусална. Төрөл бүрийн санаачилга, тэдгээрийн үр дүнгийн тоймтой байх нь төрд үр дүнтэй арга барил, загваруудыг тодорхойлоход тусалж, мөн эдгээр хандлагыг хараахан нэвтрүүлээгүй байгаа нөхцөлд нэвтрүүлэх боломжийг зааж өгч чадна. Хяналт шинжилгээ нь одоо байгаа үйлчилгээнүүдийн цоорхойг илрүүлж, цаашдын үйл ажиллагаанд мэдээлэл өгөхөд тусалдаг. Дэлхийн түвшинд хяналт шинжилгээ нь улс орнуудад амжилттай болсон (эсвэл үгүй) боловсролын хөтөлбөрүүдийн талаар туршлагаа хуваалцахад тусалдаг. Ингэснээр тэд өөрсдийн нөхцөл байдалд аль арга нь хамгийн сайн тохирохыг илүү сайн тодорхойлж чадна.</p>
<p>Мэдээллийн эх сурвалж</p>	<p>Хяналт тавих, тайлагнах үүрэгтэй хүмүүс Боловсролын яам (Үнэлгээний хүчин зүйл 4.1, 4.2, 4.3) болон дээд боловсролын яам(Үнэлгээний хүчин зүйл 4.4) зэрэг байгууллагуудтай нягт хамтран ажиллах хүсэлт гаргаж болно. Боловсролын эрдэм шинжилгээний байгууллага, багш бэлтгэх байгууллага нь хөтөлбөр боловсруулах, заах аргын талаар судалгаа хийж болох бөгөөд тэдгээрийн үр нөлөөг үнэлэх, үр дүнд нь хяналт тавих үүрэгтэй. Багш болон албан бус сурган хүмүүжүүлэгчдийг бэлтгэх хөтөлбөрийг ихэвчлэн дээд боловсролын яамны удирдлага дор багш бэлтгэх байгууллагууд явуулах бөгөөд сургалтын хөтөлбөр, арга барил нь хүртээмжтэй байх ёстой.</p> <p>Эх сурвалжууд:</p> <ul style="list-style-type: none"> ● Боловсролын сургалтын хөтөлбөр эсвэл сургалтын стандарт

	<ul style="list-style-type: none">● Багш бэлтгэх байгууллагуудын сургалтын хөтөлбөр, хичээлийн жагсаалт● Боловсрол, дээд боловсролын яамдын тайлан● Боловсролын статистик, судалгаа, үнэлгээний талаар боловсролын амжилтын жилийн эсвэл үечилсэн тайлан● ТХЗ 4, ялангуяа 4.7-н тайлан● Боловсролын хөтөлбөрийн загвар, сурган хүмүүжүүлэх арга, хандлагын талаархи судалгааны үр дүн.
--	--